

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 09 сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 09 сарын 18-ны өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-33, Танан төвийн 3 давхрын хурлын танхимд зохион байгуулагдав.

10:00 цагт Хурлын дарга хурлыг нээж тооллогын комиссын дарга Намхайдоржийг хурлын ирц танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга хурлын ирцийг танилцуулав. “Эм Жи Эл Акуа” ХК нь гаргасан нийт 327,555,616 ширхэг энгийн хувьцаатай ба үүнээс саналын эрхгүй хувьцаа байхгүй болно.

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 84.76% буюу 277,652,425 ширхэг хувьцаа эзэмшиж буй 22 хувьцаа эзэмшигч ирцээ баталгаажуулан хуралд оролцов. Үүнээс 22,883,601 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч ҮЦК-иараа дамжуулан, 250,060,290 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч хуралд саналын хуудсаар дамжуулан саналаа өгөв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц 84.76%-иар хүчин төгөлдөр болсноор хурлын дарга С.Санасэр ТУЗ-ийн дарга С.Алтантуяаг индэрт урив. ТУЗ-ийн дарга компанийн 2024 оны хагас жилийн үр дүнг танилцуулав. Үүний дараа хурлын дарга С.Санасэр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцууллаа.

Өөрийн биеэр ирж ирцийн баталгаажуулалт хийж, саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчид:

- ҮЦК-иар дамжуулан саналын хуудсаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Нийт саналын эрхтэй хувьцаанд эзлэх хувь /%/	Санал өгсөн хэлбэр
1	Мөнхбаясгалан	122	0,000000372	ҮЦК-р дамжуулан
2	Мөнхөө	22,883,242	0.69	ҮЦК-р дамжуулан
3	Болдбаатар	1	0,00000000001	ҮЦК-р дамжуулан
4	Энх-Амар	112	0,0000000341	ҮЦК-р дамжуулан
5	Золбаяр	29	0,00000000885	ҮЦК-р дамжуулан
6	Ундрал	11	0,0000000335	ҮЦК-р дамжуулан
7	Соёлт – Од	84	0,000000256	ҮЦК-р дамжуулан
	Нийт	22,883,601	0.7%	

Хуралд өөрийн биеэр ирж ирцээ баталгаажуулан хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын хуудсаа өөрийн биеэр авчирч өгсөн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Нийт саналын эрхтэй хувьцаанд эзлэх хувь /%/	Санал өгсөн хэлбэр
1	Ти эм эл трейд ХХК	240,000,000	73	саналын хуудсаар
2	Амарбаясгалан	5,628	0,0000171	саналын хуудсаар
3	Нумујиле	11,250	0,0000343	саналын хуудсаар
4	Ундрал	2,853,997	0,0087	саналын хуудсаар
5	Капитал грөүт партнерс	5,747,130	0,017	саналын хуудсаар
6	Баярзул	5495	0,0000167	саналын хуудсаар
7	Гантулга	1,436,790	0,0043	саналын хуудсаар
	Нийт	250,060,290	76.34%	

Хурлаар хэлэлцсэн асуудлуудын жагсаалт:

1. “Эм Жи Эл Акуа” ХК-ийн дүрмийг батлах;
2. ТУЗ-ийн 2024 оны төсөв;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Тооллогод хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 98.3% буюу 272,943,891 ширхэг хувьцаа эзэмшиж буй 14 хувьцаа эзэмшигчдийн саналыг авсан ба үүнээс 272,943,891 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч ҮЦК-иараа дамжуулан, 250,060,290 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саналаа ирүүлсэн. Хуралд оролцсон 22 хувьцаа эзэмшигчдээс 8 хувьцаа эзэмшигч саналын хуудас ирүүлээгүй.

Хувьцаа эзэмшигчид дараах асуудлуудад ердийн аргаар санал өгөв:

1. Хурлын дарга компанийн дүрмийн төслийг бүрэн уншиж танилцуулав. Компанийн дүрэмд эрхлэх үйл ажиллагааны чиглэлээс Моторт тээврийн хэрэгслийн худалдаа, Хүнс, ундаа тамхины бөөний худалдаа чиглэлийг тус тус хасаж, компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд Ундаа усны үйлдвэрлэл, Катерингийн үйлчилгээ, Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлүүдийг тус тус нэмснийг онцлов. “Эм Жи Эл Акуа” ХК-ийн дүрмийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 98.3% буюу 272,943,891 ширхэг хувьцаатай 14 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн** байна.
2. ТУЗ-ийн 2024 оны цалин, урамшууллыг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 98.3% буюу 272,943,891 ширхэг хувьцаатай 14 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **97.4% зөвшөөрсөн, 2.6% татгалзсан, 0% түдгэлзсэн** байна.

Хурлын дарга хэлэлцэх 3 дахь асуудал болох ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулгыг хувьцаа эзэмшигчдэд бүрэн уншиж танилцуулсан байв. Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар санал өгөв:

3. Хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд өгсөн санал:

Ердийн гишүүн:

	ТУЗ-ийн ердийн гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	С.Алтантуяа	9.64	241,015,200
2	Х.Тэгшээ	9.66	241,308,410
3	Б.Ундрал	9.65	241,029,665
4	Б.Баярзул	0.04	1,010,000
5	Х.Хүмүүжил /Humujile/	0.04	1,022,250
6	Б.Амарбаясгалан	0.04	1,030,652
7	О.Сансар /Shansier/	9.64	241,010,000
8	Л.Билгүүн	11.71	292,741,403
9	Г.Мөнх-Эрдэнэ	1.07	26,699,073
10	М.Дөлгөөн	17.85	445,952,178

Тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн ердийн гишүүнд сонгогдов. Үүнд:

1. С.Алтантуяа
2. Х.Тэгшээ
3. Б.Ундрал
4. О.Сансар /Shansier/
5. Л.Билгүүн
6. М.Дөлгөөн

Хараат бус гишүүн

	ТУЗ-ийн хараат бус гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Д.Басандорж	9.68	242,015,100
2	С.Санасэр	9.68	242,015,098
3	Ч.Анхбаяр	9.68	242,008,000

Тус тус санал авч дараах гишүүд хараат бус гишүүнд сонгогдов. Үүнд:

1. Д.Басандорж
2. С.Санасэр
3. Ч.Анхбаяр

Тооллогын комиссын дарга хэлэлцэх асуудлаар өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналыг уншиж дууссаны дараагаар хурлын дарга ХЭХ-ын тогтоолыг доорх байдлаар уншиж танилцуулав.

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 18

№1

Улаанбаатар хот

Компанийн дүрмийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, дахь заалт болон Эм жи эл акуа ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Эм жи эл акуа” хувьцаат компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээс Моторт тээврийн хэрэгслийн худалдаа, Хүнс, ундаа тамхины бөөний худалдаа чиглэлийг тус тус хасаж, компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд Ундаа усны үйлдвэрлэл, Катерингийн үйлчилгээ, Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлийг нэмсүгэй.
2. “Эм жи эл акуа” хувьцаат компанийн дүрмийг энэхүү тогтоолын Хавсралт №1 -р баталсугай.
3. Компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хороо, бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх, нийтэд мэдээлэхтэй холбоотой арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Х.Тэгшээ)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С. САНАСЭР

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 18

№ 2

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.13 дахь заалт болон 2024 оны 09 сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг нийт 600,000,000 төгрөгөөр баталсугай.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С. САНАСЭР

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 18

№ 3

Улаанбаатар хот

**Эм жи эл акуа ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон Эм жи эл акуа ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:
Ердийн гишүүдэд:

1. С.Алтангуяа
2. Х.Тэгшээ
3. Б.Ундрал
4. О.Сансар /Shansier/
5. Л.Билгүүн
6. М.Дөлгөөн

Хараат бус гишүүдэд

1. Д.Басандорж
2. С.Санасэр
3. Ч.Анхбаяр

нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С. САНАСЭР

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг 12 цаг 20 минутанд танилцуулан дуусч, хурлын дарга хурлыг хаав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ НБД / Б.Ундрал/

Хурлын дарга:

/С.Санасэр/